



МОНГОЛ УЛСЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

┌ Барилгын ажлын аюулгүй ажиллагааг ┐
хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5³ дугаар зүйлийн 5³.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг.Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.1.Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд барилгын ажлын аюулгүй байдлыг хангуулах, барилгын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах;

1.2.Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журмыг баталж, хэрэгжилтийг хангах;

1.3.Барилгын ажлын аюулгүй ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагыг мөрдөөгүй, энэ албан даалгаврыг хэрэгжүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагын барилгын ажлыг зогсоох, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг Зөвшөөрлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

Хоёр.Захиалагч, хөрөнгө оруулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад:

2.1.Барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах;

2.2.Барилгын ажил эхлэхийн өмнө тухайн барилгын ажлын талбай, түүний гаднах эрсдэл бүхий орчинд гарч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.3.Барилгын ажлын талбайн орц, гарц, талбайн хашааны гадна талд мэдээллийн самбар, ажлын талбайн зохион байгуулалтын зургийг нийтэд харагдахуйц байдлаар байршуулах;

1526100002

2.4.Хороолол, бичил хорооллын дунд барилгын ажил гүйцэтгэхдээ тухайн орчинд ажиллаж, амьдарч байгаа иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг алдагдуулахгүй байх, нийтийн эзэмшлийн зам талбайг ашиглах, замын орц, гарцыг хаах зэрэг асуудлыг захиалагч зохих журмын дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч ажиллах;

2.5.Захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч хамтран барилгын ажлын талбайн гаднах эрсдэл бүхий орчны хил хязгаарыг барилгын ерөнхий өндөр, өргөх байгууламжийн үйлчлэлийн хүрээ, аюултай бүс зэргийг үндэслэн тогтоож, зураглал үйлдэн баталгаажуулсан байх;

2.6.Барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд магадлал хийлгэсэн байх;

2.7.Барилгын ажлыг түр зогсоосон бол тогтоосон хугацаанд хамгаалалтын горимыг хангаж ажиллах;

2.8.Барилгын ажлын талбайд ажиллаж байгаа инженер техникийн ажилтан бүрийг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангаж, түүнтэй холбоотой зардлыг гаргах;

2.9.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтын хөтөлбөр боловсруулж, төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулах, зардлыг хариуцаж, үр дүнг дүгнэж ажиллах.

Гурав.Гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад:

3.1.Барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг, барилгын ажлын талбайд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааврыг боловсруулж, мөрдөх;

3.2.Барилгын ажлын аюулгүй ажиллагааг хангах зорилгоор ажилчдын байр, аюултай бүсийг тогтоож, гадна хашаа, шат, унах аюулаас хамгаалах тор, хаалт, хашлага хамгаалалтыг зохих стандартын дагуу хийж гүйцэтгэх;

3.3.Барилгын ажлын талбай, түүний гаднах эрсдэл бүхий орчинд аюулгүй байдлыг хангах, барилгын ажлын талбайг нийтийн эзэмшлийн зам талбайгаас зориулалтын түр хашаагаар тусгаарлах, хашаа нь стандартын шаардлага хангасан, хот, суурин газрын өнгө үзэмжид нийцсэн, хүн зорчих хэсэгт өндрөөс унах эд зүйлийн ачааллын үйлчлэлийг тэсвэрлэх, зориулалтын материалаар хийсэн хамгаалалтын үргэлжилсэн саравчийг хийж орчны аюулгүй байдлын хангах;

3.4.Өргөх байгууламжийн үйлчлэлийн хүрээнд гудамж, зам талбай, зэргэлдээ барилга болон барилгын ажлын талбай дахь түр байр орж байвал сумны эргэлт, өнгийлт, ачааны тэргэнцэрийн шулуун явалтыг хязгаарлах, өргүүрийг камержуулах зэрэг техникийн арга хэмжээг урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.5.Барилга байгууламжийн угсралтын ажлын явцад цахилгаан шатны хонгилд инженер техникийн ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг унах эрсдэлээс сэргийлж тэмдэг тэмдэглэгээг хийж, зориулалтын бус материалаар хонгилын нүхийг бөглөхгүй байх;

3.6.Барилгын угсралтын талбайд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу байрлуулах;

3.7.Ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хангагдаагүй инженер техникийн хэрэгслээр бүрэн хангагдсан, инженер техникийн ажилчдыг барилгын ажлын талбайд нэвтрүүлэх, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангагдаагүй инженер техникийн ажилчдыг барилгын ажлын талбайд нэвтрүүлэхгүй байх;

3.8.Барилга угсралтын талбайн харуул хамгаалалт, хяналтыг сайжруулах, бүрэн камержуулах;


3.9.Гуравдагч этгээдийн амьдрах, ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөлийг зөрчихгүй, саад учруулахгүй байх.

3.10.Оршин суугчид олноор суурьшсан нутаг дэвсгэр буюу төсөл хэрэгжүүлж буй үйлдвэрлэлийн орчинд хүнхээл, нүх, суваг, шуудуу ухах зэрэг газар шорооны ажил гүйцэтгэхдээ хүмүүсийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй газруудад тухайн байршлын онцлогт нийцүүлсэн хаалт, хамгаалалт, гүүрэн гарц хийх

3.11.Бетон зуурмаг хүлээн авах, цутгах, цахилгаан доргиур ажиллуулах үед гарах дуу чимээ, шороо тоосны улмаас ойр орчмын байрны оршин суугчдын тав тухыг алдагдуулах байдал үүсгэхгүй байхаар ажлыг зохион байгуулах, урьдчилан зөвшөөрөл авах, дуу чимээний хэмжээг стандартын шаардлагын хэмжээнд байлгах, шөнө ажиллах цаг хугацааг хязгаартай байлгах, ажиллах нөхцөл шаардлагын талаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Дөрөв.Энэ албан даалгаврыг холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахад хяналт тавьж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Хяналт шалгалтын газар, “Монголын Барилгын үндэсний ассоциаци” ТББ, “Монголын Барилгын инженерүүдийн холбоо” ТББ, захиалагч, зохиогч, гүйцэтгэгч байгууллагуудад, албан даалгаврын хэрэгжилтийг хангахад нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангаж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Найрамдал), Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газарт тус тус даалгасугай.

Тав.Энэ албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраад үүрэг болгосугай.



Э.БАТ-АМГАЛАН